



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар A115

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журмын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон Сангийн яамнаас 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан Улсын 2025 оны төсвийн онцлог болон орон нутгийн төсвийн төслийг боловсруулах чиглэл бүхий сургалтын зардалд 1,302,000 (нэг сая гурван зуун хоёр мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 21-ний өдрийн
175 дугаар захирамжийн хавсралт

Хэнтий аймгийн 2024 оны 12 дугаар сарын 19-ний
ИТХ-ийн төлөөлөгчдийн өдрийн хоолны төсөв

Хаана: Kh ресторанд 13:00 цагаас

д/д	Хоолны нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Сүүтэй цай/2 аяга/	42 хүн	1 хүний 31.000т багц /талх цөцгий дагалдана/	1.302.000т
2	Бинтэй хар шөл			
3	Нарийн махан хуурга			